



СОЁМБОМ ЭДЭЭ

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

23 /237/

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

2022.01.31

ЦАГ ҮЕ, ҮЙЛ ЯВДАЛ

Түүхэнд энэ өдөр

"ИРАКИЙН ЭРХ ЧӨЛӨӨ" АЖИЛЛАГААНД ОРОЛЦСОН ЦЭРГИЙН АЛБА ХААГЧИД ЧУУЛЖ БАЙНА

1938 он.

1938 Ардын СнЗ-ийн 4 дүгээр тогтоолоор Улсыг Батлан Хамгаалах Зөвлөлийг СнЗ-ийн дэргэд шинэчлэн байгуулав.



Монгол Улсын Зэвсэгт хүчнээс "Иракийн эрх чөлөө" дайны дараах сэргээн босголт, олон улсын хүмүүнлэгийн ажиллагаанд үүрэг гүйцэтгэсэн цэргийн багуудын удирдлага оролцсон хэлэлцүүлгийг 1 дүгээр сарын 28-ны өдөр Зэвсэгт хүчний 013 дугаар ангийн Соёлын төвд зохион байгуулсан юм.

ЗХЖШ-ын даргын баталсан "Монгол цэрэг энхийг дэмжих ажиллагаанд оролцож эхэлсний 20 жилийн ойг угтаж хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө"-нд тусгасны дагуу энэхүү хэлэлцүүлгийг ЗХЖШ-ын Бодлого, стратегийн төлөвлөлтийн газар болон Ажиллагааны удирдлагын газрын Энхийг дэмжих ажиллагааны хэлтсээс зохион байгууллаа.

Хэлэлцүүлэгт "Иракийн эрх чөлөө" дайны дараах сэргээн босголт, олон улсын хүмүүнлэгийн ажиллагаанд 2003 оноос хойш болон Ажиллагааны удирдлагын газрын Энхийг дэмжих ажиллагааны хэлтсээс зохион байгууллаа.

оролцсон Монгол Улсын Зэвсэгт хүчний 10 ээлжийн 1200 гаруй цэргийн алба хаагчдыг төлөөлсөн цэргийн багуудын захирагч, удирдах албан тушаалтнууд оролцож, тун сонирхолтой ярилцлагыг өрнүүлэв.

Энэ үеэр Цэргийн баг тус бүрийн үүрэг гүйцэтгэсэн үеийн онцлог, тухайн ажиллагааны үеийн туршлага, сургамж, үр дүн, бие бүрэлдэхүүний үүрэг гүйцэтгэлт, тэдгэнтэй зохион байгуулсан сургалт бэлтгэл, сэтгэл зүйн болон материал, техникийн хангалт, бүтээлч үйл ажиллагааны талаар мэдээлэл хийж, харилцан санал бодлоо солилцсон юм.

Уг хэлэлцүүлгийн төгсгөлд цэргийн багуудын түүх, туршлага, сургамж, үйл ажиллагааг илтгэсэн баримтат кино, ном, гэрэл зургийн цомгийг бүтээх ажилд ашиглах баримт, дүрс бичлэг, гэрэл зургууд, цэргийн алба хаагчдын дурсамжийг нэгтгэх ажлууд явагдлаа.

Монгол цэрэг энхийг дэмжих ажиллагаанд оролцож эхэлсний 20 жилийн ойг угтсан бүтээлч ажлууд цаашид улам идэвхжиж үргэлжлэх болно.

Хурандаа Б.ОТГОНБАЯР

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
-15	-33

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
35	23

ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD	2,851.0	2,853.0
EUR	3,190.0	3,200.0
CNY	448.00	449.50
RUB	37.50	38.60
JPY	24.60	24.90
KRW	2.38	2.39

ЗУРХАЙ

2022.01.31 ДАВАА ГАРАГ /БИЛГИЙН ТООЛЛЫН 29/

ӨВЛИЙН АДАГ ЦАГААГЧИН ҮХЭР САР НАЙМАН ЦАГААН МЭНГЭТЭЙ ХӨХ БИЧ ӨДӨР

Үс засуулбал:

Сүлд тэнэж одно НАРАН УРГАХ, ШИНГЭХ: 08.21-17.50

Барилдлага:

Сүлд тэнэж одно ШҮТЭН БАРИЛДЛАГА: Идэр

Суудал:

Сансар

Тухайн өдөр нохой, хонь жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн. Өдрийн сайн цаг нь хулгана, үхэр, луу, могой, хонь, нохой болой. Эл өдөр баяр баясаалангийн хурим үйлдэх, шинэ гэр барих, хувцас өмсөх, чимэг зүүх, бүжиг наадам үүсгэхэд сайн, бурханы ёс ба тарни бүтээх, амраг нөхдийг хураахуйд сайн. Баруун чих хангинавал асрагдах, зүүн нь бол буян арвижих, нохой уливал гэрийн тэнгэр зайлсан, хэрээ гуаглавал эд агуурс олдох, тагнай загатнавал зочин ирэх, бие татвал гаслан болох, хөл татвал хувцас олно.

ДОРНЫН ЗУРХАЙ:

Үс засуулбал сүлд тэнэж одно

ХУГАЦААТ ЦЭРГИЙН АЛБА ХААГЧДЫН ТӨРСӨН ӨДРИЙГ ТЭМДЭГЛЭН ӨНГӨРҮҮЛЛЭЭ

30КМ-ЫН ЯВГАН МАРШААР ...



Зэвсэгт хүчний 032 дугаар анги Анги сар бүр хугацаат цэргийн алба хаагчдын төрсөн өдрийг тэмдэглэн өнгөрүүлдэг уламжлалтай. Төрсөн өдөр тэмдэглэн өнгөрүүлдэг ажиллагаа нь цэрэг дайчдын цаашдын амьдралд мартагдахааргүй дурсамж, түүх болон үлдэх учиртай. 2022 оны 01 дүгээр сард төрсөн хугацаат цэргийн алба хаагчдын төрсөн өдрийн баярыг тэмдэглэх арга хэмжээг 2022 оны 1 дүгээр сарын 28-ны өдөр зохион байгууллаа. Уг ажиллагаанд зочноор мөрөөдлийн театрын захирал МУСТА жүжигчин Г.Эрхэмбаяр оролцож, төрсөн өдөр нь тохиож буй хугацаат цэргийн алба хаагчдад баярын мэндчилгээ дэвшүүлэн, гарын бэлэг

гардуулж, Монголын уран сайхны "Этгээд" шинэ киноны нээлтийн ажиллагааны улаан хивсний ёслолд оролцох эрхийг бэлэглэлээ. Түүнчлэн тус төрсөн өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх ажиллагаанд МУСТА Е.Дашзэвэг, ахлах ахлагч Я.Бямбасүрэн, дэд түрүүч Ю.Гүррагчаа нар ая дууны мэндчилгээ өргөн дэвшүүллээ. Төрсөн өдрийн ажиллагаанд LIVE телевизийн уран бүтээлчид оролцон, хугацаат цэргийн алба хаагчдын өдөр тутмын үйл ажиллагаа, цэргийн сургалт бэлтгэлийг ард иргэдэд сурталчилж, иргэн-цэргийн харилцааг бэхжүүлсэн арга хэмжээ боллоо.



Зэвсэгт хүчний 110 дугаар анги Ангийн 2021-2022 оны сургуулийн жилийн сургалтын төлөвлөгөөний дагуу байнгын бие бүрэлдэхүүн болон хугацаат цэргийн алба хаагчдын үүрэг гүйцэтгэлт бэлэн байдлыг хангах, бие бялдар, сэтгэл зүйн бэлтгэлжилтийн түвшинг дээшлүүлэх зорилгоор 2022 оны 1 дүгээр сарын 26-ны өдөр 30км-ын явган маршийг зохин байгуулав.

Тус маршийг Зэвсэгт хүчний 186 дугаар ангийн сургалтын төвд явуулсан бөгөөд буудлага, биеийн тамирын шалгалт, тэсэлгээний

хичээлийг төлөвлөн осол гэмтэлгүй амжилттай явуулан явуулсан юм. Түүнчлэн сургалтын төгсгөлд 30км-ын явган маршийг тактик жагсаалын хичээлтэй хослуулан зохион явууллаа.

Мөн энэ сарын 28-ны өдөр тусгай төлөвлөгөөгөөр үндсэн болон хуулиар хүлээсэн бусад үүрэг гүйцэтгэх томилгоот бүлгүүдийг дадлагын дохиогоор ажиллуулж, бэлэн байдлыг шалгаж, заагдсан районд гаргаж үүрэг гүйцэтгэх дадлагыг хийлгэсэн юм.

Дэслэгч Д.ДАВААЖАРГАЛ



МОНГОЛ УЛС ДАХЬ КОРОНАВИРУСИЙН МЭДЭЭ

I ТУН 2,268,377 +169,7%/	II ТУН 2,168,827 +166,7%/	ДАРХЛАА СЭРГЭЭХ I ТУН 979,390 +130,0%/
-----------------------------	------------------------------	---

ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ

НИЙТ БАТЛАГДСАН 7864 +112	ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БУЙ 196	ЭДГЭРСЭН 7556
------------------------------	----------------------------	------------------

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол Нийт: 366,912,057
Эдгэрсэн Нийт: 290,161,862
Нас барсан Нийт: 5,656,950



Цахим шууданд

АРТИЛЛЕРЧИД ЯВГАН МАРШИЙГ ХҮНДРҮҮЛСЭН НӨХЦӨЛД ГҮЙЦЭТГЭВ



Зэвсэгт хүчний 120 дугаар анги

Тус ангийн 2021-2022 оны сургалтын төлөвлөгөөний дагуу 30 км явган маршийг 1 дүгээр сарын 28-ны өдөр хүн нэг бүрийн байлдааны хэрэгсэлтэйгээр зохион

байгууллаа. Маршийн явцад офицер, ахлагч нар буудлагын нэгдүгээр дасгал, цэргийн гэрээт болон хугацаат албаны түрүүч байлдагч нар буудлагын анхны дасгал боловсрууллаа. Мөн энэ үеэр тактикийн

ажиллагааг гүйцэтгэх, хүч задлан, атаканд шилжих, буудлага хийж, гранат шидэх, агаарын дайралт, байр зүйн бэлтгэл, хордсон район туулах зэрэг таван цэгт үүрэг гүйцэтгүүллээ.

Ахмад Г.БИЛГҮҮНБААТАР

ТАКТИКИЙН ХЭЭРИЙН СУРГУУЛИАР ...



Зэвсэгт хүчний 327 дугаар анги

Ангийн 2021-2022 оны сургуулийн жилийн сургалтын төлөвлөгөөний "Мэргэшүүлэх шат"-ны төгсгөлд тактикийн хээрийн сургуулийг энэ сарын 26-ны өдөр сургуулийн төвийн районд амжилттай зохион байгууллаа. Мотобуудлагын салааны байлдааны буудлагаар үндсэн салбарын Миномет, Гаубиц, Зенитийн салаануудын байлдааны буудлагыг явуулсан юм. Мөн БНМАУ-ын баатар, ЗХУ-ын 4 удаагийн баатар, ЗХУ-ын маршал Г.К.Жуковын нэрэмжит Зэвсэгт хүчний 327 дугаар анги билгийн тооллын XVII дугаар жарны "Буян үйлдэгч" хэмээгч усан бар жилийн сар шинийн баярыг угтаж, уламжлал болон тогтсон "Есөн цагааны бэлгэдэл" тэмцээнийг 1 дүгээр сарын 28-ны өдөр

бүрэлдэхүүнийхээ дунд халдвар хамгааллын дэглэмийг баримтлан зохион байгуулж явууллаа. Энэхүү уламжлалт тэмцээн нь үндэсний соёл, зан заншил, сар шинийн баярын ёсон, уламжлалт тоглоом, наадгайг бие бүрэлдэхүүн, тэдний үр хүүхэд, залуучуудад сурталчлах, түгээн дэлгэрүүлэх зорилготой юм. Тэмцээнд 16 баг тамирчид оролцсон бөгөөд тэд удирдамжийн дагуу багийн мэндчилгээ, Монгол зан үйлтэй холбоотой асуулт хариулт, шагай үүрэх, сээр цохих, шагай харвах, алаг мэлхий, 5 метр мяндсаар хазаар зангидах, гэрийн даалгавар гэсэн төрлүүдээр өрсөлдөн тоглож, уламжлалт зан үйлээр "амьсгалсан" өдөр болов. Ийнхүү тэмцээний тэргүүн байрт Инженер, цацраг, хими биологис

хамгаалахын албаны "Дөрвөн бэрх" баг, дэд байрт Ажиллагааны удирдлагын тасгийн "Аравт" баг, гутгаар байрт Холбооны албаны "Шинэ сар" багийн тамирчид эзэллээ. Тамирчдад ангийн захирагч, хурандаа Н.Цэцэнхүү баяр хүргэж, амжилт хүссэн. Тэрээр "Цэргийн алба хаагч гэдэг нийгэмд ч, гэр бүлдээ ч удирдан чиглүүлэгч, манлайлагч нь байх ёстой хүмүүс. Ялангуяа, эх орныхоо уламжлалт зан үйл, соёл уламжлалыг мэддэг, түгээн дэлгэрүүлдэг байх ёстой. Монгол хүн бүр түүх уламжлал, ёс заншлынхаа тээгч учраас манай уламжлалт тэмцээний зорилго нь өөрөө энэ юм" гээд ангийн бие бүрэлдэхүүнд УОК, төр засгийн шийдвэрийг дагаж, гэр гэртээ шинэлэхийг уриаллаа.

Ахмад Д.ГАНБААТАР

Эрүүл мэнд

АНТИБИОТИКИЙГ ЗӨВ ХЭРЭГЛЭЭБҮТЭЭГДЭХҮҮН

Антибиотик гэж юу вэ? Нянгийн эсрэг сонгомол нөлөөтэй биологийн гаралтай. Вирусээр үүсгэгдсэн ханиад томуу болон суулгалтыг эдгээдэггүй.

ТА АНТИБИОТИКИЙГ ЗӨВХӨН ЭМЧИЙН ЗААВРААР, ЖОРООР АВЧ ХЭРЭГЛЭЭРЭЙ

Антибиотикийг жороор хэрэглэхийн ач холбогдол:

Эмч таны өвчинд тохирох антибиотикийг сонгож өгнө. Ямар тунгаар өдөрт хэдэн удаа, хэд хоног хэрэглэхийг зааж өгнө. Эмчийн зааврын дагуу хэрэглэснээр таны өвчин бүрэн эдгэх болно.




Антибиотикийг буруу хэрэглэвэл:

Хэрэглэх заалтгүй өвчний үед хэрэглэвэл Өвчний шинж тэмдгийг бүдгэрүүлж, оношлоход төвөгтэй болдог. Өвчин архагшина.

Тунг хэтрүүлэн хэрэглэвэл:

Зөвхөн өвчин үүсгэгч нянг устгаад зогсохгүй, хүний биед ашигтай бусад нянгуудыг устгаж мөөгөнцөр, вирус зэрэг бичил биетэн үржих боломжийг бүрдүүлдэг. Эмийн гаж нөлөө ихсэх, хордох, эрхтэн системийг гэмтээх аюултай. Заасан хугацааны турш гүйцэд хэрэглээгүй, өвчний зовуурь арилмагц хэрэглээхээ боливол: Эмчилгээ дутуу хийгдэнэ. Өвчин үүсгэгч нян дасан зохицож, тухайн антибиотикт дасалтай болдог.



Антибиотикийг зөв хэрэглэх:

Антибиотикийг ууж хэрэглэхдээ хооллосноос 30-60 минутын дараа захлахгүй залгиж хэрэглэнэ.

Зөв зохистой хэрэглэсэн эм амьдралыг тэтгэж Буруу хэрэглэсэн эм хор учруулж чаддаг. Эмийг хоол мэт хэрэглэхгүйн тулд хоолыг эм мэт зөв хэрэглээрэй.

Антибиотикийг хэрэглэхэд анхаарах зүйл:

Хэрэв ямар нэгэн антибиотик танд таардаггүй бол эмчид үзүүлэхдээ заавал хэлээрэй. Тухайн антибиотикийг уух боломжтой үед хэзээ ч тариагаар бүү хэрэглээрэй.

Антибиотикийг ялангуяа хүүхэд, жирэмсэн эмэгтэй, хөхүүл эхэд маш болгоомжтой хэрэглээрэй.

Эмчийн заасан тунгаар тогтмол цагт, тогтоосон хугацааны турш гүйцэд хэрэглэх.

Антибиотикийг хэрэглэхэд анхаарах зүйл:

Антибиотик хэрэглэсэн даруйд арьс улайж, тууралт гарах, загатнах, амьсгал давчдах болон харшлын ямар нэг шинж илэрвэл хэрэглээхээ зогсоож эмчдээ даруй мэдэгдээрэй. Хугацаа дууссан бол бүү хэрэглээрэй.

ЗӨВ СОНГОЛТ-ЭРҮҮЛ АМЬДРАЛ ЭМИЙН ЗОХИСТОЙ ХЭРЭГЛЭЭ

"Хоолны үеэр ууна" гэж заасан байвал уг эмийг дангаар нь уусан тохиолдолд ходоодны салт бүрхэвчийг гэмтээдэг гэсэн үг. Тиймээс заавал хоол идсэний дараа хэрэглээрэй. Гэхдээ алим жимс, жигнэмгээр хооллосон үедээ эм уух хэрэггүй.

Харшлын эсрэг эм, нойрны болон даралт бууруулах үйлчилгээтэй эмийг архины төрлийн ундаатай хольж уух хэрэггүй. Энэ нь таныг дүйнгэ, унтаа байдалтай болгоно.

Хэрэв "Усаар даруулна" гэсэн заавартай бол та эм усныхаа дараа ганц балга бус, нэг аяга ус ууна гэсэн үг. Харин "хоолны өмнө ууна" гэдэг нь хоол идэхээс хоёр цагийн өмнө уух ёстойг анхааруулж байгаа хэрэг юм.

Аспириныг жимсний сироп, элсэн чихэр найрлагад нь ороогүй шингэн жимсний шүүсээр даруулж болно. Хавдрын эсрэг эм уухдаа цус төлжүүлэх яргай загас, элэг, түрс, лийр зэргийн хэрэглэх нь зохимжтой.

Цэргийн төв эмнэлэг

Хоол боловсруулах эрхтэн судлалын тасгийн сувилагч ахлагч **С. ОЮУНТУНГАЛАГ**, сувилагч **Б. АЛТАНЦЭЦЭГ**, эм зүйч **Г. НОМИН-ЭРДЭНЭ**